



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/090/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025 оны 02 дүгээр сарын 15</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор: Н.Бүнчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	21

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2025.02.07 № 2/03
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймаг дахь Политехник коллежийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитын дүгнэлтийн үндэслэл болгосон зөрчил дутагдал нь төлөвлөлтийн шатанд бидний урьдчилан тогтоосон материаллаг байдлаас хэтрээгүй.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Тайлант хугацаанд гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орлогоор 64.2 сая төгрөгөөр төвлөрүүлэхээр төлөвлөснөөс 35.8 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.

5020170

Тайланд онд цалингийн зардал 268.5 сая, бараа үйлчилгээний бусад зардал 171.5 сая, хичээл үйлдвэрлэлийн дадлага 136.8 сая төгрөг зэрэг нийт 626.6 сая төгрөг хэмнэсэн нь төлөвлөлт бодитой бусыг харуулж байна

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 97.4 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	357,004,693.11	952,918,140.48
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	593,428,705.51
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	593,428,705.51
3121	Төгрөг	-	593,428,705.51
31211	Төрийн сангийн харилцах	-	593,428,705.51
33	АВЛАГА	4,592.00	9,890,568.68
33102	НДШ-ийн авлага		198,753.68
33203	ХАОАТын авлага	-	9,691,815.00
335	Бусад авлага	4,592.00	-
3351	Байгууллагаас авах авлага	4,592.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	357,000,101.11	349,598,866.29
351	Түүхий эд материал	268,077,002.61	245,742,434.78
35110	Тусгай зориулалттай материал	268,077,002.61	245,131,434.78
35130	Эм боох материал	-	611,000.00
354	Хангамжийн материал	88,923,098.50	103,856,431.51
35410	Бичиг хэргийн материал	6,960,330.00	9,851,930.00
35420	Аж ахуйн материал	59,282,968.50	73,639,668.50
35430	Сэлбэг хэрэгсэл	2,014,000.00	584,000.00
35440	Түлш, шатах тослох материал	600,000.00	100,000.00
35450	Барилгын засварын материал	10,040,900.00	9,306,400.00
35460	Хүнсний материал	-	280,533.01
35470	Бусад хангамжийн материал	10,024,900.00	10,093,900.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,602,439,829.23	2,552,361,274.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,602,439,829.23	2,552,361,274.46
392	Биет хөрөнгө	1,821,339,829.23	1,700,261,274.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,072,620,064.61	2,072,620,064.61
39202	Хуримтлагдсан элэгдэл	(749,019,722.10)	(844,332,810.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	167,364,900.00	178,364,900.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(160,421,655.00)	(167,548,233.33)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,848,257,589.42	1,874,657,589.42
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,492,617,095.30)	(1,579,955,577.14)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	216,051,080.00	242,199,080.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(169,069,727.23)	(180,073,047.76)
39214	Бусад үндсэн хөрөнгө	27,217,953.00	37,717,953.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(20,053,254.07)	(21,248,140.18)
39217	Ном	81,009,695.90	87,859,495.90
393	Биет бус хөрөнгө	781,100,000.00	852,100,000.00
39301	Програм хангамж	1,760,735.00	1,760,735.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,760,735.00)	(1,760,735.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	781,100,000.00	852,100,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,959,444,522.34	3,505,279,414.94
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,378,124.00	1,143,197.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,378,124.00	1,143,197.00
413	Өглөг	5,378,124.00	1,143,197.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,033,724.00	1,143,197.00
4136	Бусад өглөг	344,400.00	-
41361	Байгууллагад төлөх өглөг	344,400.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,954,066,398.34	3,504,136,217.94
51	Засгийн газрын хувь оролцоо	2,954,066,398.34	3,504,136,217.94
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,945,234,164.54	1,945,234,164.54
51101	Өмч: - төрийн	1,945,234,164.54	1,945,234,164.54
512	Хуримтлагдсан үр дүн	(462,347,478.39)	87,722,341.21
51210	Өмнөх үеийн үр дүн	(368,598,149.14)	(462,007,670.39)
51220	Тайлант үеийн үр дүн	(93,749,329.25)	549,730,011.60
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,471,179,712.19	1,471,179,712.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,959,444,522.34	3,505,279,414.94

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,790,892,300.00	4,765,021,750.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	119,283,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	119,283,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		108,298,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		10,985,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,790,892,300.00	4,645,738,750.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,217,240,200.00	4,099,853,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,217,240,200.00	4,099,853,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,464,100.00	35,777,150.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,464,100.00	35,777,150.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	537,188,000.00	510,108,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	537,188,000.00	510,108,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,919,718,929.25	4,215,291,738.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,919,718,929.25	4,215,291,738.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,134,864,925.49	3,984,980,751.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,779,501,407.87	2,524,968,966.00
210101	Үндсэн цалин	1,779,040,792.87	1,390,409,419.00
210102	Нэмэгдэл	460,615.00	879,421,161.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	108,116,293.00
210104	Урамшуулал	-	147,022,093.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	246,498,200.45	326,063,150.32
210201	Тэтгэврийн даатгал	167,637,766.53	221,782,713.32
210202	Тэтгэмжийн даатгал	19,715,533.73	26,070,139.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,772,146.18	13,035,011.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,942,986.55	13,035,011.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,429,767.46	52,140,276.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	490,033,532.72	485,768,821.71
210301	Гэрэл, цахилгаан	20,254,748.72	19,507,791.71
210302	Түлш, халаалт	407,843,396.00	409,297,759.00
210303	Цэвэр, бохир ус	21,935,388.00	21,963,271.00
210304	Байрны түрээс	40,000,000.00	35,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	55,399,849.20	80,847,710.00
210401	Бичиг хэрэг	5,241,950.00	27,958,410.00
210402	Тээвэр, шатахуун	4,485,520.00	9,250,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,910,399.20	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,625,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,136,980.00	43,639,300.00
2105	Нормативт зардал	61,929,475.00	59,403,268.93
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	697,300.00	611,100.00
210502	Хоол, хүнс	58,713,475.00	57,278,568.93
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,518,700.00	1,513,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	59,623,150.00	32,699,180.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	620,000.00	12,319,000.00
210604	Урсгал засвар	59,003,150.00	20,380,180.00
2107	Томилолт, зочны зардал	547,200.00	-
210702	Дотоод албан томилолт	547,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,930,475.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,738,975.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	4,847,100.00	-
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	344,400.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	429,401,635.25	475,229,654.60
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,495,000.00	59,547,237.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	144,228,942.00	213,706,062.83
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	270,677,693.25	201,976,354.77

Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	784,854,003.76	230,310,986.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,173,061.00	225,617,088.56
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,967,961.00	80,164,738.56
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,816,200.00	141,958,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,388,900.00	3,494,350.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	657,526,475.48	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	657,526,475.48	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,154,467.28	4,693,898.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,154,467.28	4,693,898.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(128,826,629.25)	549,730,011.60
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(128,826,629.25)	549,730,011.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,790,892,300.00	4,645,738,750.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,790,892,300.00	4,645,738,750.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,217,240,200.00	4,099,853,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,217,240,200.00	4,099,853,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,464,100.00	35,777,150.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,464,100.00	35,777,150.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	537,188,000.00	510,108,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	537,188,000.00	510,108,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,707,303,600.00	4,008,710,244.49
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,707,303,600.00	4,008,710,244.49
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,922,449,596.24	3,778,393,607.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,774,467,683.87	2,538,503,933.00
210101	Үндсэн цалин	1,063,766,692.92	1,403,944,386.00
210102	Нэмэгдэл	516,238,779.29	879,421,161.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	62,742,000.00	108,116,293.00
210104	Урамшуулал	131,720,211.66	147,022,093.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	246,498,200.45	326,309,279.00
210201	Тэтгэврийн даатгал	167,637,766.53	222,028,842.00
210202	Тэтгэмжийн даатгал	19,715,533.73	26,070,139.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,772,146.18	13,035,011.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,942,986.55	13,035,011.00
210205	Эрүүл мэндийн даатгал	39,429,767.46	52,140,276.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	490,033,532.72	485,768,821.71
210301	Гэрэл, цахилгаан	20,254,748.72	19,507,791.71
210302	Түлш, халаалт	407,843,396.00	409,297,759.00
210303	Цэвэр, бохир ус	21,935,388.00	21,963,271.00
210304	Байрны түрээс	40,000,000.00	35,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,781,579.20	-
210401	Бичиг хэрэг	4,900,100.00	-
210402	Тээвэр, шатахуун	5,215,400.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,334,199.20	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэргэгчдийн устгал, ариутгал	5,125,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,206,880.00	-
2105	Нормативт зардал	71,892,825.00	57,559,101.93
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	697,300.00	-
210502	Хоол, хүнс	57,625,525.00	57,559,101.93
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,570,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	80,383,500.00	52,257,680.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	19,826,000.00	32,612,000.00
210604	Урсгал засвар	60,557,500.00	19,645,680.00
2107	Томилолт, зочны зардал	547,200.00	-

Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	547,200.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,742,575.00	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,895,475.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	4,847,100.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	202,102,500.00	317,994,792.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,495,000.00	127,234,297.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	187,607,500.00	190,760,495.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	784,854,003.76	230,316,636.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	124,173,061.00	225,622,738.56
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,967,961.00	80,164,738.56
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	36,816,200.00	141,958,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,388,900.00	3,500,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	657,526,475.48	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	657,526,475.48	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	3,154,467.28	4,693,898.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,154,467.28	4,693,898.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	83,588,700.00	637,028,505.51
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	78,820,000.00	43,599,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	78,820,000.00	43,599,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	78,820,000.00	43,599,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	78,820,000.00	43,599,800.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(78,820,000.00)	43,599,800.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	4,768,700.00	593,428,705.51
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	593,428,705.51

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,179,712.19	-462,347,478.39	2,954,066,398.34
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,179,712.19	-462,347,478.39	2,954,066,398.34
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,179,712.19	-462,347,478.39	2,954,066,398.34
D01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,179,712.19	-462,347,478.39	2,954,066,398.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	339,808.00	339,808.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,179,712.19	-462,007,670.39	2,954,406,206.34
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	549,730,011.60	549,730,011.60
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,945,234,164.54	1,471,179,712.19	87,722,341.21	3,504,136,217.94

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,674,191,900.00	4,047,616,146.20	626,575,753.80	86.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,674,191,900.00	4,047,616,146.20	626,575,753.80	86.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,443,468,900.00	3,821,993,407.64	621,475,492.36	86.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,806,994,100.00	2,538,503,933.00	268,490,167.00	90.4
210101	Үндсэн цалин	1,421,120,300.00	1,403,944,386.00	17,175,914.00	98.8
210102	Нэмэгдэл	1,277,183,800.00	879,421,161.00	397,762,639.00	68.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	108,690,000.00	108,116,293.00	573,707.00	99.5
210104	Урамшуулал	-	147,022,093.00	(147,022,093.00)	
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	350,874,300.00	326,309,279.00	24,565,021.00	93.0
210201	Тэтгэврийн даатгал	238,594,500.00	222,028,842.00	16,565,658.00	93.1
210202	Тэтгэмжийн даатгал	28,069,900.00	26,070,139.00	1,999,761.00	92.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,035,000.00	13,035,011.00	999,989.00	92.9
210204	Ажилгүйдлийн даатгал	14,035,000.00	13,035,011.00	999,989.00	92.9
210205	Эрүүл мэндийн даатгал	56,139,900.00	52,140,276.00	3,999,624.00	92.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	490,108,400.00	485,768,821.71	4,339,578.29	99.1
210301	Гэрэл, цахилгаан	21,810,000.00	19,507,791.71	2,302,208.29	89.4
210302	Түлш, халаалт	409,298,400.00	409,297,759.00	641.00	100.0
210303	Цэвэр, бохир ус	24,000,000.00	21,963,271.00	2,036,729.00	91.5
210304	Байрны түрээс	35,000,000.00	35,000,000.00	-	100.0
2105	Нормативт зардал	67,424,000.00	57,559,101.93	9,864,898.07	85.4
210502	Хоол, хүнс	67,424,000.00	57,559,101.93	9,864,898.07	85.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	58,092,500.00	52,257,680.00	5,834,820.00	90.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	38,092,500.00	32,612,000.00	5,480,500.00	85.6
210604	Урсгал засвар	20,000,000.00	19,645,680.00	354,320.00	98.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	669,975,600.00	361,594,592.00	308,381,008.00	54.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	342,380,100.00	170,834,097.00	171,546,003.00	49.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	327,595,500.00	190,760,495.00	136,835,005.00	58.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	230,723,000.00	225,622,738.56	5,100,261.44	97.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	230,723,000.00	225,622,738.56	5,100,261.44	97.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	85,265,000.00	80,164,738.56	5,100,261.44	94.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	141,958,000.00	141,958,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,500,000.00	3,500,000.00	-	100.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,674,191,900.00	4,641,044,851.71	33,147,048.29	99.3
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,099,853,200.00	4,099,853,200.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	4,099,853,200.00	4,099,853,200.00	-	100.0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	510,108,400.00	505,414,501.71	4,693,898.29	99.1
132001	Орон нутгийн төсвөөс	510,108,400.00	505,414,501.71	4,693,898.29	99.1
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	64,230,300.00	35,777,150.00	28,453,150.00	55.7

Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	64,230,300.00	35,777,150.00	28,453,150.00	55.7
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	593,428,705.51	(593,428,705.51)	
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	94	94	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	83	83	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	10	10	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баянхонгор аймаг дахь Политехникийн коллеж нь Мэргэжлийн боловсролын сургалтын үйл ажиллагааг суралцагчийн эрхийг дээдлэн, суралцах, дадлагажих нөхцлөөр хангаж, сургалтын чанар, хүртээмж, үр дүнг дээшлүүлэх зорилгын хүрээнд

- Багш, ажиллагсдын мэргэжил, ур чадварын тасралтгүй хөгжлийг хангах
- Мэргэжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, цахим е-технологийн арга зүйг нэвтрүүлэн сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх
- Суралцагчийн олон нийтийн ажилд сайн дураар оролцох, зохион байгуулах дадал хэвшлийг төлөвшүүлэхэд асран хамгаалагчдын үүрэг оролцоог нэмэгдүүлэх
- Багш, ажиллагсад, суралцагчдын судалгаа, шинжилгээ, инновацийн ажлыг дэмжин урамшуулах
- Төсөл хөтөлбөр, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх
- “Чанартай сургалт-Бүтээлч түншлэл” зорилгыг хэрэгжүүлэн төгсөгчдийг хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх
- Бүс, орон нутгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтанг бэлтгэх
- Гүйцэтгэлд суурилсан төлөвлөлт, санхүүжилтийн тогтолцоог эхлүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь сангийн сайдын 2018 оны тушаалаар баталсан “төсөвт байгууллагын жишиг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарт нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлог тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймаг дахь Политехникийн коллеж нь 2024 оны санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 3,505,279.4 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 545,834.9 мянган төгрөгөөр буюу 18.4 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	593,428.7	593,428.7
Авлага	4.6	9,890.6	9,886.0
Бараа материал	357,000.1	349,598.9	(7,401.2)
Үндсэн хөрөнгө	5,195,382.0	5,347,279.8	151,897.8
Хуримтлагдсан элэгдэл	(2,592,942.2)	(2,794,918.5)	(201,976.4)
Нийт хөрөнгө	2,959,444.5	3,505,279.4	545,834.9
Өр төлбөр	5,378.1	1,143.2	(4,234.9)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,954,066.4	3,504,136.2	550,069.8
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,959,444.5	3,505,279.4	545,834.9

Эх сурвалж: Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл данс 593,428.7 мянган төгрөг байгаа нь харилцах дансны үлдэгдэл 593,428.7 үлдэгдэлтэй гарсантай холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 9,890.6 мянган төгрөг байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 198.7 мянга, ХАОАТ-ын авлага 8,951.3 мянган төгрөгийн үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 349,598.9 мянган төгрөг болж 7,401.2 мянган төгрөг буурсан нь төсвийн хөрөнгөөр 380,891.4 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, оёдлын ангийн дадлагын материалын орлогоос 7,550.0 мянга, 3,435.0 мянган төгрөгийг хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч 399,277.7 мянган төгрөгийн хөрөнгийг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,347,279.8 мянга байгаа нь 151,897.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 43,599.8 мянга, үнэ төлбөргүй 108,298.0 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлэн авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,504,136.2 мянган төгрөг болж 550,069.8 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 549,730.0 мянга, өмнөх үеийн үр дүн 339.8 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төслийг төлөвлөхдөө мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суралцагч хүүхдийн тоо, тэтгэвэрт гарах албан хаагч, 6 сарын тэтгэмж албан хаагчийн мэдээллийг хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 4,674,191.9 мянган төгрөг батлагдсанаас 4,047,616.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,047,616.1 мянган төгрөг буюу 86.6 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 626,575.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	81834 Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хэтэлбөрийг хэрэгжүүлэх	3,580,695.2	3,111,973.9	468,721.3	87%
2	81806 Дотуур байрны үйлчилгээ	67,424.0	57,559.1	9,864.9	85%
3	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	230,723.0	225,622.7	5,100.3	98%
4	81835 Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	221,011.0	112,691.5	108,319.5	51%
5	80111 Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	510,108.4	505,414.5	4,693.9	99%
6	81844 Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт	64,230.3	34,354.4	29,875.9	53%
	Нийт дүн	4,674,191.9	4,047,616.1	626,575.8	87%

Эх сурвалж: Төсвийн гүйцэтгэлийн тайлангаас

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Үндсэн үйл ажиллагааны зардлаас хэмнэсэн 593,428.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа ба үүний 293,055.2 мянган төгрөг нь цалин, НДШ-ийн зардал, 308,391.0 мянган төгрөг бараа үйлчилгээний зардлыг хэмнэсэн байна. Энэ нь 1,062 хүүхдээр хувьсах зардлаар төсөв батлагдаж ирсэн ба 952 хүүхэд дунджаар

суралцаж байгаатай холбоотой байна. Мөн тайлант онд тогтмол зардалд 510,108.4 мянган төгрөгийн төсөв гүйцэтгэлээр 505,414.5 мянган төгрөгийг зарцуулж 4,693.9 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллага нь нэмэлт санхүүжилтийн данс байхгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Баянхонгор аймаг дахь Политехникийн коллеж 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, ахлах аудитор М.Алтантуяа, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр ирүүлсэн.

2024 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Д.Бат-Орших 2024 оны 1 дүгээр сараас 6 сар хүртэл, Т.Бат-Ирээдүй 6 сарын 12 сар хүртэл, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Д.Баатархуяг нар зурж хөрөнгийг захиран зарцуулжээ.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн нийт зардлыг сонгож, материаллаг байдлын түвшин 1.0 хувиар тооцож материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны анх батлагдсан төсвийн нийт зардлын 4,164,083.5 мянган төгрөгөөс тооцоход 41,640.8 мянган төгрөг байгаа ба

гүйцэтгэлийн материаллаг байдлыг 65 хувиар буюу 27,066.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тухайн байгууллага нь төрийн тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг байгууллага тул орон тооны болон тээврийн хэрэгслийн хязгаарлалт үйлчлэхгүй бөгөөд бусад хэмнэлттэй холбоотой заалтуудыг зөрчөөгүй болно.

Төрийн хэмнэлтийн хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2024 оны гэрэл цахилгааны зардлыг 2,302.2 мянга, цэвэр бохир усны зардлыг 2,036.7 мянга нийт тогтмол зардал 4,439.6 мянга буюу 0.9 хувь хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь 2024 онд 171 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 166 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, 5 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Тайлант онд шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 4,561,657.5 мянган төгрөгийн 45 гүйлгээ цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын 896,283.7 мянган төгрөгийн 44 гүйлгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 92,820 мянган төгрөгийн 16 мэдээллийг байршуулсан байна.

Шилэн дансны цахим хуудсанд түлш халаалт, түрээс, хоол, хичээл практикийн дадлагын материалын гэрээнүүдийг байршуулаагүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар 66,455.7 мянган төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 5,048.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 60,557.5 мянган төгрөгийн зөрчил арилгах 1 албан шаардлага хүргүүлсэн ба Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн 2024 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 126 дүгээр албан бичгээр хэрэгжилтийг 100 хувиар тооцсон байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт /мянган төгрөгөөр/		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	5,898.2	1	5,898.2	100.0
Албан шаардлага	1	60,557.6	1	60,557.6	100.0
Нийт дүн	4	66,455.7	4	66,455.7	100.0

Эх сурвалж: 2024 оны аудитын тайлангаас

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 06 сарын 24-ны өдрийн 2/2772 тоот албан бичгээр 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар "Өөрчлөлтгүй" гэж дүгнэгдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт балансын урамшуулал өгөх чиглэл өгсний дагуу тус байгууллагын захирлын 2024 оны 07 сарын 02-ны өдрийн Б/32 дугаар тушаалаар ерөнхий нягтлан бодогч, тооцооны нягтлан бодогч, нярав нарт тус бүр 2 сарын үндсэн цалингаар балансын урамшуулалд 7,930.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчдад мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна." гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул дараагийн аудитаар анхаарах шаардлагатай гэж үзэж байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 41,870.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад залруулав. Үүнд:

1.Тус байгууллага нь оны эхэнд ХАОАТ-ын өглөг 4,986.3 мянган өглөгтэй байсан бөгөөд нягтлан бодогч өмнөх үеийн үр дүн хааж бичсэн байна.Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4², 4 дүгээр зүйлийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Үнэн зөв байх

4.1.1³, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

2. Төрийн албаны цалингийн нэгдсэн системээс тус байгууллагын цалин татаж мөнгөн гүйлгээний журнал болон ерөнхий дэвтэртэй тулган шалгахад цалингаас суутгасан ХАОАТ-ын авлагыг 740.5 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд дутуу тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5⁴ заалтууд, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3. Төрийн албаны цалингийн нэгдсэн системээс тус байгууллагын цалин татаж мөнгөн гүйлгээний журнал болон ерөнхий дэвтэртэй тулган шалгахад цалингаас суутгасан, ҮЭ-ийн өглөгийг 1,143.2 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд дутуу тусгасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 20 дугаар зүйлийн 20.2.5 заалтууд, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, үнэлгээ ба хуваарилалт, эрх ба үүрэг батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

4. Тайлант он орон нутгийн төсвөөс авах санхүүжилтээс дансны хуулгаар 510,108.4 мянган төгрөгийн санхүүжилт авсан байхад санхүүгийн тайланд 475,108.4 мянга буюу 35,000.0 мянга, байрны түрээсийн зардлыг 35,000.0 мянга тус тус дутуу бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, УСНББОУС 23 Арилжааны бус ажил гүйлгээний орлого (татвар ба шилжүүлэг), НББОУС 18 Орлого, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 14,937.6 мянган төгрөгийн зөрчил⁵ илэрснээс 1,539.6 мянган төгрөгийн төлбөрийн акт, 332.9 мянган төгрөгийн 1 зөрчлийг арилгах албан шаардлага, 13,065.1 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлэв.

5.1. Төлбөрийн акт

1. Тус байгууллагын захирал нь ээлжийн амралтын олговрыг 7 сарын цалинтай давхардуулан дээд газрын тушаал шийдвэргүйгээр 1,143.2 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь "Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.1⁶-д заасан заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хууль зөрчин олгосон амралтын цалин 3,127.2 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Санхүүгийн тайланд тусгагдсан оны эхний үлдэгдлээр байгаа бусад зардлын тооцооны авлага 0.5 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 47.4 мянган төгрөг,

³ Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө

⁴ Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

⁵ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

⁶ Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно.

байгууллагад төлөх өглөг 344.4 мянган төгрөгийг нягтлан бодогч өмнөх оны үр дүн рүү бичсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4⁷, 20.2⁸-д заасан заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны үр дүн рүү бичиж хаасан 0.5 мянган төгрөгийн авлага, НДШ-ийн 47.4 мянган төгрөгийн өглөг, байгууллагад төлөх 344.4 мянган төгрөгийн өглөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Нэг албан хаагчийн 6 сарын амралтын цалин 332.9 мянган төгрөгийн НДШ-ийг мэдээлээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 зүйлийн 17.1 дэх хэсэгт “1.Ажил олгогч болон энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан даатгуулагч нь шимтгэл төлөх талаар дор дурдсан үүрэг хүлээнэ” 17.1.1⁹-д заасан заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нэг албан хаагчийн 332.9 мянган төгрөгийн НДШ-ийг нөхөн мэдээлэх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

1.Тайлант хугацаанд гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орлогоор 64,230.3 мянган төгрөгөөр төвлөрүүлэхээр төлөвлөсөн ба 34,777.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн гэж тайлагнасан боловч үүний 29,453.2 мянган төгрөг нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас орж ирсэн санхүүжилт бөгөөд дадлагын орлогоос харилцах дансанд 5,742.1 мянга, бараа материалын тайланд 15,970.0 мянган төгрөгийн суралцагчдын хийсэн дээл, хормогч гэх мэт материалуудыг орлого авч 13,065.0 мянган төгрөгийн орлого ороогүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2¹⁰-т заасан заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дадлагын хичээлийн журмыг шинэчлэн боловсруулж, дадлагын хичээлээс орох орлогыг бодитой төлөвлөх зөвлөмжийг хүргүүлж байна.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

⁷ хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх

⁸ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах

⁹ Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх

¹⁰ Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих

**Баянхонгор аймаг дахь Политехникийн коллежийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тус байгууллага нь оны эхэнд ХАОАТ-ын өглөг 4,986.3 мянган өглөгтэй байсан бөгөөд нягтлан бодогч өмнөх үеийн үр дүн хааж бичсэн байна	1	4,986.3			1	4,986.3	1	4,986.3				
ХАОАТ-ын авлагыг 740.5 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд дутуу тусгасан байна.	1	740.5	1	740.5			1	740.5				
ҮЭ-ийн өглөгийг 1,143.2 мянган төгрөгөөр санхүүгийн тайланд дутуу тусгасан байна.	1	1,143.2	1	1,143.2			1	1,143.2				
санхүүгийн тайланд 475,108.4 мянга буюу 35,000.0 мянга, байрны түрээсийн зардлыг 35,000.0 мянга тус тус дутуу бүртгэсэн байна	1	35000.0	1	35,000.0			1	35,000.0				
Дүн	4	41,870.0	3	36,883.7	1	4,986.3	4	41,870.0				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус байгууллагын захирал нь ээлжийн амралтын олговрыг 7 сарын цалинтай давхардуулан дээд газрын тушаал шийдвэргүйгээр 1,143.2 мянган төгрөгийг олгосон байна.	1	1,143.2	1	1,143.2				
Санхүүгийн тайланд тусгагдсан оны эхний үлдэгдлээр байгаа бусад зардлын тооцооны авлага 0.5 мянган төгрөг, НДШ-ийн өглөг 47.4 мянган төгрөг, байгууллагад төлөх өглөг 344.4 мянган төгрөгийг нягтлан бодогч өмнөх оны үр дүн рүү бичсэн байна.	1	396.4	1	396.4				
С.Төгсгэрэлийн 6 сарын амралтын цалин 332.9 мянган төгрөгийн НДШ-ийг мэдээлээгүй байна.	1	332.9			1	332.9		
Тайлант хугацаанд гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалтын орлогоор 64,230.3 мянган төгрөгөөр төвлөрүүлэхээр төлөвлөсөн ба 34,777.1 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн гэж тайлагнасан боловч үүний 29,453.2 мянган төгрөг нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас орж ирсэн санхүүжилт бөгөөд дадлагын орлогоос харилцах дансанд 5,742.1 мянга, бараа материалын тайланд 15,970.0 мянган төгрөгийн суралцагчдын хийсэн дээл, хормогч гэх мэт материалуудыг орлого авч 13,065.0 мянган төгрөгийн орлого ороогүй байна	1	13,065.1					1	13,065.1
Дүн	4	14,937.6	2	1,539.6	1	332.9	1	13,065.1